

Ажилтан болон ажил олгогчдын анхааралд

Цалингаа цахим хэлбэрээр авах боломжтой боллоо



Хөдөлмөрийн тухай хуульд цалинг бэлнээр олгоно гэж заасан байдаг ч ажилтан өөрөө зөвшөөрсөн тохиолдолд банкны данс руу шилжүүлэн авахыг зөвшөөрдөг. Бэлэн мөнгөний хэрэглээг багасгах, мөнгө шилжүүлэх арга хэрэгслүүд олширч байгаатай холбоотойгоор ажилтан өөрөө зөвшөөрсөн тохиолдолд зарим **※мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн дансаар шилжүүлэн авах боломжтой боллоо.**

※ Үүнд зөвхөн Эрүүл мэнд, Хөдөлмөр хамгааллын Яамны сайдын заасан (●●Pay гэх мэт) мөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгжүүд орно. Тус мөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгжүүд тодорхой болсны дараа Эрүүл мэнд, Хөдөлмөр хамгааллын Яамны цахим хуудсанд тавих болно.



← ЭМХХ Яамны цахим хуудас

Цаашдын төлөвлөгөө

2023 оны 4 сараас

Мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчид нь ЭМХХЯ сайдад хүсэлт гарган, ЭМХХЯ сонгон шалгаруулалт хийнэ.(хэдэн сар шаардагдана)

Сайдын тушаалын дараа

Байгууллага тус бүртэй хөдөлмөрийн гэрээ байгуулна

Хөдөлмөрийн гэрээ байгуулсны дараа

Ажилтан нэг бүрт тайлбар хийн, хэрэв ажилтан зөвшөөрсөн тохиолдолд цалинг цахим хэлбэрээр олгож эхэлнэ.

► Анхаарах зүйлс

- Бэлэн мөнгө болгох боломжгүй оноо болон виртуал валютаар цалин олгохыг зөвшөөрөхгүй.
- Цалинг цахим хэлбэрээр олгох нь цалин олгох болон хүлээн авах хэрэглүүрийн нэг хэлбэр юм. Тус системийг нэвтрүүлсэн аж ахуй нэгж нь бүх ажилчдынхаа цалин олгож, авч байсан аргаа заавал өөрчлөх ёстой гэсэн үг биш юм.
- Хэрэв ажилтан хүсэлт гаргаагүй тохиолдолд урьдын адилаар банкны дансаар цалингаа авах боломжтой. Мөн ажил олгогч нь хүсэлт гаргаагүй ажилтанд хүчээр цахим хэлбэрээр цалин олгож болохгүй. (Ажилтны зөвшөөрөлгүй эсвэл хүчээр цахим хэлбэрээр цалинг олгосон тохиолдолд ажил олгогчийг Хөдөлмөрийн тухай хууль зөрчсөн хэмээн үзэж, торгууль тавьж болзошгүй.)
- Цалингийнхаа нэг хэсгийг нь мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчээр аван, үлдсэнийг нь банкны дансаар авах боломжтой.

Хүсэлт гаргасан ажилтан

Цалингийн нэг хэсгээ мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн дансаар авах (жишээ нь: 50,000 иен)

Үлдсэн цалингаа банкны дансаар авах гэх мэт

Хүсэлт гаргаагүй ажилтан

Цалингаа бүгдийг нь Банкны данс зэргээр авах



Цалингаа цахим хэлбэрээр авахыг хүссэн хүмүүсийн анхааралд

- **Урьдчилан хамтран ажиллах гэрээг байгуулах шаардлагатай**

Цалингаа цахим хэлбэрээр олгох гэж буй аж ахуй нэгж нь эхлээд ажил олгогч болон ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах ёстой. Түүний дараа ажил олгогч нь доорх заалтуудыг ажилтанд тайлбарлан, ажилтан нэг бүрээс зөвшөөрөл авах шаардлагатай.

- **Хүлээн авах дүнгээ тооцох хэрэгтэй**

Мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн данс нь “хадгаламж” үүсгэх бус төлбөр төлөх болон шилжүүлэг хийх зориулалттай гэдгийг ойлгосны үндсэн дээр хэрэгцээтэй дүнгээ хүлээн авах хэрэгтэй. Мөн хүлээн авах дүн нь өдөрт татан авах дээд хэмжээнээс бага байх шаардлагатай.

- **Дансны дээд хязгаар нь 1 сая иен хүртэл байна**

Дансны дээд хязгаарыг 1 сая иен буюу түүнээс бага хэмжээгээр тогтоосон. Хэрэв дээд хэмжээ хэтэрсэн бол ажилтны урьдчилж өгсөн данс руу автоматаар татан авагдана. Энэ тохиолдолд шимтгэлийг ажилтан төлж болзошгүй тул мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчээс тодруулах хэрэгтэй.

- **Дансны үлдэгдлээ бэлэн мөнгө болгох боломжтой (сард 1 удаа данснаасаа мөнгө гаргахад шимтгэлгүй)**

АТМ болон банкны данс зэргээр цахим дансанд байгаа үлдэгдлээ бэлэн мөнгө болгон авах боломжтой. Сард 1 удаа шимтгэлгүйгээр мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн данснаас мөнгөө авах боломжтой. Мөнгөө авах арга болон шимтгэл нь мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчээс хамааран өөр өөр байна.

- **10 жилийн дотор дансны үлдэгдлээ буцаан авах боломжтой**

Цахим дансны үлдэгдлийг хүсэлтийн дагуу сүүлийн орлого зарлага хийсэн өдрөөс хойш 10 жилийн дотор буцаан олгох боломжтой.

▶ Гэнэтийн тохиолдолд

- **Хуурамч гүйлгээ хийгдсэн тохиолдолд**

Данс хулгайлагдах зэргээс үүдэн мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгчийн данснаас хуурамчаар мөнгө татан авагдсан тохиолдолд данс эзэмшигч буруугүй бол хохирлыг бүрэн барагдуулах боловч хэрэв ажилтан өөрөө буруутай нь тогтоогдвол тус бүрд нь хэргийг авч хэлэлцэнэ. Мөн хуурамч гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш 30-аас доошгүй хоногийн дотор мэдэгдэх хэрэгтэй. Хэрэв хуурамч гүйлгээ хийгдсэн тохиолдолд түргэн шуурхай мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч рүү мэдэгдэнэ үү.

- **Мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч нь татан буугдсан тохиолдолд**

Мөнгөн хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэгч нь татан буугдсан тохиолдолд даатгалын компаниас нөхөн төлбөрийг барагдуулна.



Хүмүүс, Аж амьдрал, Ирээдүйн төлөө

Эрүүл мэнд, Хөдөлмөр
Хамгааллын Яам